

**АШИГЛАСАН ТҮЛШНИЙ БОЛОН ЦАЦРАГ ИДЭВХТ ХАЯГДЛЫН
МЕНЕЖМЕНТИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ НЭГДСЭН КОНВЕНЦ**

Удиртгал

Хэлэлцэн тохиролцогч талууд

- (i) цөмийн реакторын үйл ажиллагаа нь ашигласан түлш болон цацраг идэвхт хаягдал бий болгодог ба цөмийн технологийн бусад хэрэглээ нь мөн цацраг идэвхт хаягдал үүсгэдэг болохыг хүлээн зөвшөөрч;
- (ii) аюулгүй ажиллагааг хангах нь ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментэд нэгэн адил хамаарах зорилт болохыг хүлээн зөвшөөрч;
- (iii) ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах үр нөлөө бүхий практик ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх нь олон улсын хамтын нийгэмлэгт чухал ач холбогдолтойг дахин баталж;
- (iv) ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг олон нийтэд мэдээлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрч;
- (v) цөмийн аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн үр нөлөө бүхий соёл, ухамсрыг дэлхий дахинд дэлгэрүүлэхийг эрмэлзэн;
- (vi) ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүрэг хариуцлагыг улс хүлээх ёстойг дахин нотолж;
- (vii) зарим улс ашигласан түлшийг булшилдаг бол зарим улс түүнийг дахин боловсруулж болох үнэт эх үүсвэр хэмээн тооцдог зэргийг харгалzan түлшний циклийн бодлогыг хэрхэн тодорхойлох нь тухайн улсын шийдвэрлэх асуудал болохыг хүлээн зөвшөөрч;
- (viii) цэргийн, эсхүл батлан хамгаалахын хөтөлбөрийн хүрээнд ашиглагдах, энэхүү конвенцын үйлчлэлд үл хамаарах ашигласан түлш болон цацраг идэвхт хаягдлыг энэхүү конвенцод тодорхойлсон зорилгод нийцүүлэн зохицуулах шаардлагатайг хүлээн зөвшөөрч;
- (ix) хоёр болон олон талт тогтолцоо болоод энэхүү шинэ конвенцод тулгуурлан ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын

гэрчилсаныг тайлбарилцааны яам

АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

20.08.2018-ны 20-р сарын 20-р
Улаанбаатар хот

- менежментийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг нотолж;
- (x) хөгжиж буй улсууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй улсууд болон шилжилтийн эдийн засагтай улсуудын хэрэгцээ, шаардлагыг анхаарахын зэрэгцээ тэдгээр улсад энэхүү шинэ конвенцын дагуу хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үүднээс одоогийн тогтолцоог хялбарчлах хэрэгцээ, шаардлага байгааг санан;
- (xi) цацраг идэвхт хаягдлыг тухайн материалын менежментийн аюулгүй ажиллагааг харгалзан үүссэн улсад нь булшлах ёстой гэдэгт итгэлтэй байхын зэрэгцээ тодорхой тохиолдолд нэгөө талуудын ашиг сонирхлын үүднээс, ялангуяа хаягдал үүсгэж буй хамтарсан төслийн хувьд нэг талын нутаг дэвсгэрт байгаа байгууламжийг ашиглах зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд хурсэн тохиролцооны арга замаар ашигласан түлш болон цацраг идэвхт хаягдлын аюулгүй, үр ашигтай менежментийг хөгжүүлэх боломжтойг хүлээн зөвшөөрч;
- (xii) аливаа улс бусад улсын ашигласан түлш болон цацраг идэвхт хаягдлыг өөрийн нутаг дэвсгэрт импортоор оруулахыг хориглох эрхтэйг хүлээн зөвшөөрч;
- (xiii) Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц (1994 он), Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенц (1986 он), Цөмийн осол болон цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусlamж үзүүлэх тухай конвенц (1986 он), Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц (1980 он), Хог хаягдал болон бусад зүйлийг хаях замаар далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай конвенц (нэмэлт, өөрчлөлт орсон) (1994 он) болон холбогдох бусад олон улсын баримт бичгийг харгалзан;
- (xiv) байгууллага хоорондын “Ионжуулагч цацрагаас хамгаалах болон цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааны тухай олон улсын аюулгүй ажиллагааны үндсэн стандарт” (1996 он), Олон улсын атомын энергийн агентлагийн аюулгүй ажиллагааны үндсэн баримт бичиг болох “Цацраг идэвхт хаягдлын менежментийн зарчмууд” (1995 он) болон цацраг идэвхт материалын тээвэрлэлтийн аюулгүй ажиллагаатай холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын стандартуудад тусгалаа олсон зарчмуудыг харгалзан;
- (xv) Рио де Жанейро хотноо 1992 онд хуралдсан Нэгдсэн Үндэстний харилцааны яам Байгууллагын “Байгаль орчин ба хөгжлийн асуудлаарх бага хурал”.

ын хөтөлбөрийн 21 дүгээр асуудлын 22 дугаар бүлэгт цацраг идэвхт хаягдлын менежмент аюулгүй бөгөөд байгаль орчинд ээлтэй байх нь дээд зэргийн чухал болохыг онцлон тэмдэглэснийг эргэн санаж;

- (xvi) Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц (1989 он)-ын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан цацраг идэвхт материалд тусгайлан хамаарч үйлчлэх олон улсын хяналтын тогтолцоог бэхжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа хүлээн зөвшөөрч;

дараахийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

**1 ДҮГЭЭР БҮЛЭГ
ЗОРИЛГО, ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ**

**1 дүгээр зүйл
Зорилго**

Энэхүү конвенцын зорилго нь:

- (i) үндэсний арга хэмжээ болон олон улсын хамтын ажиллагаа, түүний дотор шаардлагатай үед аюулгүй байдлын техникийн хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг дэлхий дахинд дээд зэргээр хангах, тогтвортой хадгалах;
- (ii) ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн бүх үе шатанд ионжуулагч цацрагийн хортой нөлөөллөөс хувь хүн, нийгэм болон байгаль орчныг эдүгээ болон хойч үед хамгаалах үр нөлөө бүхий хамгаалалтын арга хэрэгслийг бэлэн байлгах, чингэхдээ өнөө үеийн хүмүүсийн хэрэгцээ, шаардлага болон хүсэл эрмэлзэл нь хойч үеийн хүмүүсийн хэрэгцээ, шаардлага болон хүсэл эрмэлзлээ хангах чадавхад сэргээр нөлөөлөхгүйгээр хангагдаж байх нөхцөлийг бүрдүүлэх;
- (iii) ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн аливаа үе шатанд цацрагийн сөрөг үр дагавар бүхий ослоос урьдчилан сэргийлэх болон осол гарсан тохиолдолд хор уршгийг бууруулахад оршино.

**2 дугаар зүйл
Тодорхойлолт**

Энэхүү конвенцын зорилгоор:

- (a) "хаах" гэж ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлыг булшлах байгууламжид байршуулсны дараа тодорхой хугацаанд хийж гүйцэтгэх ёстой бүх ажиллагааг хийж дуусгахыг хэлнэ. Хаах ажиллагаанд байгууламжийг урт хугацаанд аюулгүй байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай эцсийн инженер, техникийн болон бусад ажил багтана.
- (b) "ашиглалтаас гаргах" гэж булшлах байгууламжаас бусад цөмийн байгууламжийг зохицуулалтын хяналтаас гаргахад чиглэсэн бүх арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээнд цацрагийн бохирдлыг арилгах болон задалж ашиглах боломжгүй болгох ажиллагаа хамаарна.
- (c) "суллах" гэж зохицуулалтад байдаг цөмийн байгууламжийн хэвийн ажиллагааны явцад гарч буй хий, шингэн төлөвтэй цацраг идэвхт материалыг зохицуулагч байгууллагаас зөвшөөрсөн хязгаарт, зөвшөөрөгдсөн практик үйл ажиллагааны дагуу тодорхой төлөвлөгөө, хяналтын дор байгаль орчинд суллах үйл ажиллагааг;
- (d) "булшлах" гэж ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлыг дахин ашиглах зорилгогүйгээр зохих байгууламжид байршуулахыг;
- (e) "тусгай зөвшөөрөл" гэж зохицуулагч байгууллагаас олгосон, ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежменттэй холбоотой аливаа үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг;
- (f) "цөмийн байгууламж" гэж цацраг идэвхт материалыг аюулгүй ажиллагааны зохих хэм хэмжээнд үйлдвэрлэх, боловсруулах, ашиглах, бэлтгэх, хадгалах, эсхүл булшлах энхийн зориулалттай байгууламж, түүнд хамаарах газар, барилга болон тоног төхөөрөмжийг;
- (g) "ашиглалтын хугацаа" гэж ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг үндсэн зориулалтаар нь ашиглах хугацааг хэлнэ. Булшлах байгууламжийн хувьд энэ хугацаа нь ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлыг байгууламжид анх байршуулсан мөчөөс эхэлж, тухайн байгууламжийг хааснаар дуусгавар болно;
- (h) "цацраг идэвхт хаягдал" гэж Хэлэлцэн тохиролцогч тал, эсхүл хувь хүн, хуулийн этгээд цаашид ашиглахгүй гэж үзсэн (хувь хүн хуулийн этгээдийн ийм шийдвэрийг тэдгээрийн харьяалах Хэлэлцэн тохиролцогч тал зөвшөөрсөн байна) хий, шингэн, эсхүл хатуу төлөвтэй байгаас, тухайн

Монгол Улсын Адмиралтэйн царилцааны яам
УЛГА МӨНХ ТУХАЙН

Гарын үсэг /Signature.....

2022 оны 06 сарын 21 өдөр
Гражданчийн хувь

Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомж болон зохицуулалтын дагуу зохицуулагч байгууллагаас цацраг идэвхт хаягдалд тооцон хянадаг цацраг идэвхт материалыг хэлнэ;

- (i) “цацраг идэвхт хаягдлын менежмент” гэж цацраг идэвхт хаягдлыг бэлтгэх, урьдчилан боловсруулах, боловсруулах, зохистой төлөвт оруулах, хадгалах, эсхүл булшахтай холбоотой байгууламжийн талбайн гаднах тээвэрлэлтээс бусад бүх ажиллагаа (ашиглалтаас гаргах ажиллагааг оролцуулан)-г хэлнэ. Үүнд суллах ажиллагаа мөн хамаарч болно;
- (j) “цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламж” гэж цацраг идэвхт хаягдлын менежментийн үндсэн зориулалтаар ашиглагдах байгууламж, эсхүл төхөөрөмжийг хэлэх бөгөөд үүнд ашиглалтаас гаргах шатанд буй цөмийн байгууламж (гагцхүү Хэлэлцэн тохиролцогч тал цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламж хэмээн тогтоосон тохиолдолд) багтана;
- (k) “зохицуулагч байгууллага” гэж ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг зохицуулах, түүний дотор тусгай зөвшөөрөл олгох эрхийг Хэлэлцэн тохиролцогч талаас авсан аливаа байгууллага, эсхүл байгууллагуудыг;
- (l) “дахин боловсруулах” гэж ашигласан тулшийг цаашид ашиглах зорилгоор түүнээс цацраг идэвхт изотопуудыг ялган авах үйл явц буюу ажиллагааг;
- (m) “битүү үүсгүүр” гэж капсулд хийж бүрмөсөн битүүмжилсэн, эсхүл нягт холбогдсон, хатуу төлөвт байгаа, реакторын түлшний элементээс бусад цацраг идэвхт материалыг;
- (n) “ашигласан түлш” гэж реакторын голомтод цацраг туяа тусгаж, түүнээс бүрмөсөн гаргасан цөмийн түлшийг;
- (o) “ашигласан түлшний менежмент” гэж ашигласан түлшийг бэлтгэх, эсхүл хадгалахтай холбоотой, талбайн гаднах тээвэрлэлтээс бусад бүх ажиллагааг хэлнэ. Үүнд суллах ажиллагаа хамаарч болно;
- (p) “ашигласан түлшний менежментийн байгууламж” гэж ашигласан түлшний менежментийн үндсэн зориулалтаар ашиглагдах аливаа төхөөрөмж, эсхүл байгууламжийг;
- (q) “хүлээн авагч улс” гэж хил дамжуулан хүргэхээр төлөвлөсөн, эсхүл хүлээн авсан улсыг;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2012 оны 12 сарын 22-өдөр
Улаанбаатар хот

- (r) "гараг үүслийн улс" гэж хил дамжуулан хүргэх ажиллагааг эхлэхээр төлөвлөсөн, эсхүл тус ажиллагаа эхэлсэн улсыг;
- (s) "дамжин өнгөрөх улс" гэж хүлээн авагч болон гарал үүслийн улсаас бусад, хил дамжуулан хүргэх ажиллагаа нутаг дэвсгэрээр нь дамжин хийгдэхээр төлөвлөгдсөн, эсхүл дамжин хийгдэж буй аливаа улсыг;
- (t) "хадгалах" гэж ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлыг дахин ашиглах зорилгоор аюулгүй байдлаар хадгалах зориулалтын байгууламжид байлгахыг;
- (u) "хил дамжуулан хүргэх ажиллагаа" гэж ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлыг гарал үүслийн улсаас хүлээн авагч улс руу тээвэрлэх ажиллагааг тус тус хэлнэ.

З дугаар зүйл Үйлчлэх хүрээ

1. Энэхүү конвенц нь энхийн зориулалтаар ашиглаж буй цөмийн реакторын ажиллагааны үр дунд үүсэх ашигласан түлшний менежментийн аюулгүй ажиллагааг хангахад үйлчилнэ. Хэлэлцэн тохиролцогч тал дахин боловсруулах үйл ажиллагааг ашигласан түлшний менежментийн шат дамжлагын нэг хэсэг хэмээн мэдэгдсэнээс бусад тохиолдолд дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд дахин боловсруулах байгууламжид хадгалж буй ашигласан түлш нь энэхүү конвенцын үйлчлэлд хамаарахгүй;
2. Энэхүү конвенц нь энхийн зориулалттай хэрэглээний үр дунд үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагаанд мөн үйлчилнэ. Гэвч зөвхөн байгалийн цацраг идэвхт материал агуулж буй, цөмийн түлшний циклээс бий болоогүй хаягдал нь энэхүү конвенцын үйлчлэлд хамаарахгүй. Ийм хаягдал нь ашиглагдахгүй болсон битүү үүсгүүрийг бий болгож буй, эсхүл түүнийг Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү конвенцын зорилгоор цацраг идэвхт хаягдал хэмээн мэдэгдсэн бол энэхүү конвенцын үйлчлэлд хамаарна.
3. Энэхүү конвенц нь Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү конвенцын зорилгоор ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдал хэмээн мэдэгдсэнээс бусад цэргийн, эсхүл батлан хамгаалах хөтөлбөрийн хүрээнд ашиглагдах ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагаанд үйлчлэхгүй. Гэвч энэхүү конвенц нь цэргийн болон батлан хамгаалах хөтөлбөрийн хүрээнд бий болсон ашигласан түлш, цацраг идэвхт материалыг гагцхүү энхийн зориулалттай хөтөлбөрт бүрмэсөн шилжүүлж, түүний хүрээнд зохицуулах тохиолдолд тэдгээрийн аюулгүй ажиллагаанд үйлчилнэ.

**Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН**

Гарын үсэг /Signature/ 

**2012 оны 06 сарын 21 өдөр
Улаанбаатар хот**

4. Энэхүү конвенц нь 4, 7, 11, 14, 24 болон 26 дугаар зүйлд заасан суллах ажиллагаанд үйлчилнэ.

2 ДУГААР БҮЛЭГ АШИГЛАСАН ТҮЛШНИЙ МЕНЕЖМЕНТИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА


4 дүгээр зүйл Аюулгүй ажиллагааны өрөнхий шаардлага

Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний менежментийн бүх үе шатанд хувь хүн, нийгэм болон байгаль орчныг цацрагийн аюулаас найдвартай хамгаалах нөхцөлийг хангах чиглэлээр зохих арга хэмжээг авна.

Чингэхдээ Хэлэлцэн тохиролцогч тал бүр:

- (i) ашигласан түлшний менежментийн явцад үүсэх үлдэгдэл дулааныг тусгаарлах, түлшийг критик утгад барьж байх асуудлыг зохих ёсоор шийдвэрлэсэн байх;
- (ii) ашигласан түлшний менежментийн явцад үүсэх цацраг идэвхт хаягдлын хэмжээг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй түлшний циклийн талаарх бодлогод нийцүүлэн практикт хүрч болохуйц хамгийн бага хэмжээнд байлгах;
- (iii) ашигласан түлшний менежмент дэх төрөл бурийн арга хэмжээний хоорондын уялдаа холбоог харгалзан үзэх;
- (iv) олон улсад мөрдөгдөг шалгуур болон стандартыг харгалзсаны үндсэн дээр үндэсний хууль тогтоомжийн хүрээнд, зохицуулагч байгууллагаас зөвшөөрсөн тохиромжтой хамгаалалтын арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх замаар хувь хүн, нийгэм болон байгаль орчныг найдвартай хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх;
- (v) ашигласан түлшний менежменттэй холбоотойгоор үүсэж болох биологийн, химийн болон бусад аюулыг харгалзан үзэх;
- (vi) өнөө үеийн хүмүүст зөвшөөрөгдсөнөөс илүү хэмжээтэй нөлөөллийг хойч үед учруулж болзошгүй аливаа үйлдлээс аль болох зайлсхийх;
- (vii) хойч үед зохисгүй хор уршиг учруулахаас зайлсхийхэд чиглэсэн зохих арга хэмжээг тус тус авна.

5 дугаар зүйл Ашиглаж буй байгууламж



Хэлэлцэн тохиролцогч тал бүр энэхүү конвенц тухайн талын хувьд хүчин төгөлдөр болох үед өөрийн ашиглаж буй ашигласан түлшний менежментийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хянаж үнэлэх, шаардлагатай бол тухайн байгууламжийн аюулгүй ажиллагааг шинэчлэх үүднээс хэрэгжүүлж болох бүхий л сайжруулалтыг хийх нөхцөлийг хангана.

6 дугаар зүйл
Шинээр барих байгууламжийн байршил сонгох

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний менежментийн байгууламж шинээр барихдаа дараах журмыг бий болгож, хэрэгжүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) тухайн байгууламжийн ашиглалтын хугацааны туршид түүний аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй байршилтай холбоотой бүх хүчин зүйлийг үнэлж тооцоолох;
- (ii) тухайн байгууламжийн хувь хүн, нийгэм болон байгаль орчинд учруулж болзошгүй аюулгүй ажиллагааны нөлөөллийг үнэлж тооцоолох;
- (iii) тухайн байгууламжийн аюулгүй ажиллагааны талаарх мэдээллээр олон нийтийг хангах;
- (iv) шинээр барих байгууламж нь түүний хөрш зэргэлдээ орших Хэлэлцэн тохиролцогч талуудад нөлөөлж болзошгүй учир тухайн талуудтай зөвлөлдөх, хүсэлт гаргасан тохиолдолд тэдгээр талуудыг ерөнхий мэдээ баримтаар хангаж, уг байгууламжаас нутаг дэвсгэрт нь учруулж болзошгүй аюулгүй ажиллагааны нөлөөллийг үнэлж тооцоолох боломжийг олгох.

2. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ Хэлэлцэн тохиролцогч тал бүр 4 дүгээр зүйлд заасан аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагад нийцүүлэн байгууламжийн байршлыг сонгоходо тухайн байгууламж нь Хэлэлцэн тохиролцогч бусад талд тааламжгүй нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангах зохих арга хэмжээг авна.

7 дугаар зүйл
Байгууламжийн зураг төсөл боловсруулах
болон барьж байгуулах

<p>Монгол Улсын Гадаад харилцааны нам АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН</p> <p>Гарын үсэг /Signature/ 20... онь... сарын... өдөр Улаанбаатар хот</p> <p>Ministry of Foreign Affairs of Mongolia OFFICIAL TRANSLATION</p>
--

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) ашигласан түлшний менежментийн байгууламжийн зураг төсөл боловсруулах болон барьж байгуулахдаа хувь хүн, нийгэм болон байгаль орчинд учирч болзошгүй цацрагийн нөлөө, түүний дотор тэдгээрийг суллах, эсхүл хяналтгүйгээр чөлөөлснөөс үүсэх цацрагийн нөлөөнөөс хамгаалах, түүнийг хязгаарлах тохиromжтой арга хэрэгслийг бий болгох;
- (ii) зураг төсөл боловсруулах үе шатанд ашигласан түлшний менежментийн байгууламжийг ашиглалтаас гаргах үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүнчлэн шаардлагатай тохиолдолд техникийн нөхцөлийг урьдчилан тооцоолсон байх;
- (iii) ашигласан түлшний менежментийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнийг барьж байгуулахад ашигласан технологи нь туршлага, туршилт, эсхүл дүн шинжилгээгээр батлагдсан байх.


8 дугаар зүйл Байгууламжийн аюулгүй ажиллагааны үнэлгээ

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) ашигласан түлшний менежментийн байгууламжийг барьж байгуулахаас өмнө тухайн байгууламжийн учруулж болзошгүй хор аюултай холбогдуулан аюулгүй ажиллагааны системтэй үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх бөгөөд чингэхдээ уг байгууламжийн ашиглалтын хугацааг харгалзан үзэх;
- (ii) ашигласан түлшний менежментийн байгууламжийг ашиглалтад оруулахаас өмнө шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ зүйлийн (i)-д заасан үнэлгээг сайжруулах үүднээс аюулгүй ажиллагааны үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинэчилсэн, дэлгэрэнгүй хувилбарыг боловсруулсан байх.

9 дүгээр зүйл Байгууламжийг ажиллуулах

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

Монгол Улсын Гадаад харилцааны яам АЛБАН ёСНЫ ОРЧУУЛГА МӨН	
Гарын үсэг /Signature: 	
2019 оны 08 сарын 22 өдөр Улаанбаатар хот 	
Ministry of Foreign Affairs of Mongolia OFFICIAL TRANSLATION	

- (i) ашигласан түлшний менежментийн байгууламжийг ажиллуулах тусгай зөвшөөрлийг 8 дугаар зүйлд заасан зохих үнэлгээнд үндэслэн, тухайн байгууламж нь баригдсан байдлаараа зураг төслийн болон аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн болохыг нотолсон ашиглалтад оруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссаны дараа олгодог байх;
- (ii) туршилт, үйл ажиллагааны туршлага болон 8 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэсэн үйл ажиллагааны нөхцөл, зааг хязгаарыг тодорхойлж, шаардлагатай бол хянан шинэчилж байх;
- (iii) ашигласан түлшний менежментийн байгууламжийг ажиллуулах, ашиглах, хяналт шалгалт хийх болон турших ажиллагааг тогтоосон журмын дагуу явуулах;
- (iv) ашигласан түлшний менежментийн байгууламжийн ашиглалтын хугацааны туршид түүний аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой бүх салбарт шаардлагатай инженер, техникийн нөөцтэй байх;
- (v) тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд нь аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх тохиолдлын талаар зохицуулагч байгууллагад цаг алдалгүй мэдэгдэж байх;
- (vi) үйл ажиллагааны туршлага хуримтлуулж, түүнд дүн шинжилгээ хийхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулах, шаардлагатай тохиолдолд гарсан үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авах;
- (vii) ашигласан түлшний менежментийн байгууламжийг ашиглалтаас гаргах төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай тохиолдолд түүнийг тухайн байгууламжийн ашиглалтын хугацаанд олж авсан мэдээллийг ашиглан шинэчилж байх бөгөөд уг төлөвлөгөөг зохицуулагч байгууллагаар хянуулж байх.

10 дугаар зүйл
Ашигласан түлшийг булшлах

Хэлэлцэн тохиролцогч тал өөрийн хууль тогтоомжийн дагуу ашигласан түлшийг булшлахаар шийдвэрлэсэн бол уг ажиллагааг 3 дугаар бүлэгт заасан цацраг идэвхт хаягдлыг булшлахтай холбоотой үүргийн дагуу гүйцэтгэнэ.

3 ДУГААР БҮЛЭГ
ЦАЦРАГ ИДЭВХТ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

<p>Гарын үсэг /Signature/ </p> <p>20²⁰ оны 20 сарын 20 едер Улаанбаатар хот</p> <p>Ministry of Foreign Affairs of Mongolia OFFICIAL TRANSLATION</p>	<p>МОНГОЛ УЛСЫН ГАЗАРЧААХАРИЛЦААНЫ ЯАМ АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН</p>
--	--

11 дүгээр зүйл Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний менежментийн бүх үе шатанд хувь хүн, нийгэм болон байгаль орчныг цацрагийн аюулаас найдвартай хамгаалах нөхцөлийг хангах чиглэлээр зохих арга хэмжээг авна.

Чингэхдээ Хэлэлцэн тохиролцогч тал бүр:

- (i) цацраг идэвхт хаягдлын менежментийн явцад үүсэх үлдэгдэл дулааныг тусгаарлах, түлшийг критик утгад барьж байх асуудлыг зохих ёсоор шийдвэрлэсэн байх;
- (ii) цацраг идэвхт хаягдлын хэмжээг практикт байж болохуйц хамгийн бага хэмжээнд байлгах;
- (iii) цацраг идэвхт хаягдлын менежмент дэх төрөл бүрийн арга хэмжээний хоорондын уялдаа холбоог харгалзан үзэх;
- (iv) олон улсад мөрддөг шалгуур, стандартыг харгалзан үндэсний хууль тогтоомжийн хүрээнд, зохицуулагч байгууллагаас зөвшөөрсөн тохиромжтой хамгаалалтын арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх замаар хувь хүн, нийгэм болон байгаль орчныг найдвартай хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх;
- (v) цацраг идэвхт хаягдлын менежменттэй холбоотойгоор үүсэж болох биологийн, химийн болон бусад аюулыг харгалзан үзэх;
- (vi) өнөө үеийн хүмүүст зөвшөөрөгдсөнөөс илүү хэмжээтэй нөлөөллийг хойч үед учруулж болзошгүй аливаа үйлдлээс аль болох зайлсхийх;
- (vii) хойч үед зохисгүй хор уршиг учруулахаас зайлсхийхэд чиглэсэн зохих арга хэмжээг тус тус авна.

12 дугаар зүйл Ашиглаж буй байгууламж болон түүний үйл ажиллагааны туршлага

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах чиглэлээр зохих арга хэмжээг авна.
Үүнд:

- (i) энэхүү конвенц тухайн талын хувьд хүчин төгөлдөр болох үед өөрийн ашиглаж буй цацраг идэвхт хаягдлын менежментийн **байгууламжийн аюулгүй ажиллагааг хянаж үнэлэх, шаардлагатай** бол Г **тухайн арилцааны яам албан ёсны орчуулга мөн**



байгууламжийн аюулгүй ажиллагааг шинэчлэх үүднээс хэрэгжүүлж болох бүхий л сайжруулалтыг хийх нөхцөлийг хангана;

- (ii) цацрагийн хамгаалалтын чиглэлээр аливаа арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор байгууламжийн үйл ажиллагааны туршлагын үр дүнг хянан үзэх, чингэхдээ тунгийн хэмжээ буурснаас шалтгаалан түүний хор хөнөөл буурсан нь тухайн арга хэмжээний хор аюул болон өртөг зардал, түүний дотор нийгмийн зардлыг зөвтгөх хангалттай үндэслэл болохыг анхаарч бодолцох.

13 дугаар зүйл
Шинээр барих байгууламжийн
байршил сонгох

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр шинээр цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламж барихдаа дараах журмыг бий болгож, хэрэгжүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үнд:

- (i) тухайн байгууламжийн ашиглалтын хугацааны туршид уг байгууламжийн, түүнчлэн булшлах байгууламжийг хаасны дараа түүний аюулгүй ажиллагаанд тус тус нөлөөлж болзошгүй байршилтай холбоотой бүх хүчин зүйлийг үнэлж тооцоолох;
- (ii) тухайн байгууламжийн хувь хүн, нийгэм болон байгаль орчинд учруулж болзошгүй аюулгүй ажиллагааны нөлөөллийг үнэлж тооцоолох, чингэхдээ булшлах байгууламжийг хаасны дараа түүний байршиж буй газрын орчин тойрны нөхцөл хувьсан өөрчлөгдж болзошгүй харгалzan үзэх;
- (iii) тухайн байгууламжийн аюулгүй ажиллагааны талаарх мэдээллээр олон нийтийг хангах;
- (iv) шинээр барих байгууламж нь түүний хөрш зэргэлдээ орших Хэлэлцэн тохиролцогч талуудад нөлөөлж болзошгүй учир тухайн Хэлэлцэн тохиролцогч талуудтай зөвлөлдөх, хүсэлт гаргасан тохиолдолд тэдгээр талуудыг ерөнхий мэдээ баримтаар хангаж, уг байгууламжаас нутаг дэвсгэрт нь учруулж болзошгүй аюулгүй ажиллагааны нөлөөллийг үнэлж тооцоолох боломжийг олгох.

2. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ Хэлэлцэн тохиролцогч тал бүр 11 дүгээр зүйлд заасан аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагад нийцүүлэн байгууламжийн байршлыг сонгоходо тухайн байгууламж нь Хэлэлцэн тохиролцогч бусад талд тааламжгүй нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангах зохих арга хэмжээг авна.



14 дүгээр зүйл
Байгууламжийн зураг төсөл боловсруулах болон барьж байгуулах

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн зураг төсөл боловсруулах болон барьж байгуулахдаа хувь хүн, нийгэм болон байгаль орчинд учирч болзошгүй цацрагийн нөлөө, түүний дотор тэдгээрийг суллах, эсхүл хяналтгүйгээр чөлөөлснөөс үүсэх цацрагийн нөлөөнөөс хамгаалах, түүнийг хязгаарлах тохиromжтой арга хэрэгслийг бий болгох;
- (ii) зураг төсөл боловсруулах үе шатанд булшлах байгууламжаас бусад цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг ашиглалтаас гаргах үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүнчлэн шаардлагатай тохиолдолд техникийн нөхцөлийг урьдчилан тооцоолсон байх;
- (iii) зураг төсөл боловсруулах үе шатанд булшлах байгууламжийг хаахад мөрдөх техникийн нөхцөлийг боловсруулсан байх;
- (iv) цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнийг барьж байгуулахад ашигласан технологи нь туршлага, туршилт, эсхүл дүн шинжилгээгээр батлагдсан байх.

15 дугаар зүйл
Байгууламжийн аюулгүй ажиллагааны үнэлгээ

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг барьж байгуулахаас өмнө тухайн байгууламжийн учруулж болзошгүй хор аюултай холбогдуулан аюулгүй ажиллагааны системтэй үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх бөгөөд чингэхдээ уг байгууламжийн ашиглалтын хугацааг харгалзан үзэх;
- (ii) түүнчлэн булшлах байгууламжийг барьж байгуулахаас өмнө түүнийг хаасны дараах үед хэрэгжүүлэх аюулгүй ажиллагааны системтэй үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх бөгөөд үнэлгээний үр дүнг зохицуулагч байгууллагаас тогтоосон шалгуураар үнэлэх;



- (iii) цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг ашиглалтад оруулахаас өмнө шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ зүйлийн (i)-д заасан үнэлгээг сайжруулах үүднээс аюулгүй ажиллагааны үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинэчилсэн, дэлгэрэнгүй хувилбарыг боловсруулсан байх.

16 дугаар зүйл Байгууламжийг ажиллуулах

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг ажиллуулах тусгай зөвшөөрлийг 15 дугаар зүйлд заасан зохих үнэлгээнд үндэслэн, тухайн байгууламж нь баригдсан байдлаараа зураг төслийн болон аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн болохыг нотолсон ашиглалтад оруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссаны дараа олгодог байх;
- (ii) туршилт, үйл ажиллагааны үр дүн болон 15 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэсэн үнэлгээний дүнд үндэслэн үйл ажиллагааны нөхцөл, зааг хязгаарыг тодорхойлж, шаардлагатай бол хянан шинэчилж байх;
- (iii) цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг ажиллуулах, ашиглах, хяналт шалгалт хийх болон турших ажиллагааг тогтоосон журмын дагуу явуулах. Булшлах байгууламжийн хувьд эдгээр ажиллагааны дүнд гарсан үр дүнг урьд өмнө хийсэн төсөөллийн үнэн бодит байдлыг шалгаж нотлох, түүнчлэн байгууламжийг хаасны дараах хугацаанд 15 дугаар зүйлд заасан үнэлгээг шинэчлэн явуулахад тус тус ашиглах;
- (iv) цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн ашиглалтын хугацааны туршид түүний аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой бүх салбарт шаардлагатай инженер, техникийн нөөцтэй байх;
- (v) цацраг идэвхт хаягдлын шинж чанарыг тодорхойлон төрөлжүүлэх, тусгаарлах ажиллагаа хийгдсэн байх;
- (vi) тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд нь аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх тохиолдлын талаар зохицуулагч байгууллагад цаг алдалгүй мэдэгдэж байх;



- (vii) үйл ажиллагааны туршлага хуримтлуулж, түүнд дүн шинжилгээ хийхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулах, шаардлагатай тохиолдолд гарсан үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авах;
- (viii) булшлах байгууламжаас бусад цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг ашиглалтаас гаргах төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай тохиолдолд түүнийг тухайн байгууламжийн ашиглалтын хугацаанд олж авсан мэдээллийг ашиглан шинэчилж байх бөгөөд уг төлөвлөгөөг зохицуулагч байгууллагаар хянуулж байх;
- (ix) булшлах байгууламжийг хаах төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай тохиолдолд түүнийг тухайн байгууламжийн ашиглалтын хугацаанд олж авсан мэдээллийг ашиглан байнга шинэчилж байх бөгөөд уг төлөвлөгөөг зохицуулагч байгууллагаар хянуулж байх.

17 дугаар зүйл
Байгууламжийг хаасны дараах зохион
байгуулалтын арга хэмжээ

Хэлэлцэн тохиролцогч тал бүр булшлах байгууламжийг хаасны дараа дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) зохицуулагч байгууллагаас тавьсан шаардлагын дагуу тухайн байгууламжийн байршил, зураг төсөл болон данс бүртгэлийг хадгалах;
- (ii) шаардлагатай тохиолдолд хяналт шинжилгээ хийх, эсхүл нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг идэвхтэй буюу идэвхгүй зохион байгуулалтын хяналт тавих;
- (iii) зохион байгуулалтын идэвхтэй хяналт хийх явцад цацраг идэвхт материал байгаль орчинд төлөвлөөгүй байдлаар алдагдаж байгаа нь илэрвэл шаардлагатай тохиолдолд тухайн нөхцөл байдлыг шийдвэрлэх арга хэмжээ авах.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААЛТ

18 дугаар зүйл
Хэрэгжүүлэх арга хэмжээ

Хэлэлцэн тохиролцогч тал бүр үндэснийхээ хууль тогтоомжийн хүрээнд энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн, зохицуулалтын болон захиргааны арга хэмжээ болоод шаардлагатай бусад алхмыг авч хэрэгжүүлнэ.

19 дүгээр зүйл
Эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах харилцааг зохицуулсан эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлнэ.
2. Эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо нь дараах зохицуулалтыг агуулсан байна. Үүнд:
 - (i) цацрагийн аюулгүй ажиллагааг хангахад тавигдах үндэсний шаардлага болон дүрэм, журмыг бий болгох;
 - (ii) ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх тогтолцоог бүрдүүлэх;
 - (iii) ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг тусгай зөвшөөрөлгүйгээр ажиллуулахыг хориглосон тогтолцоог бүрдүүлэх;
 - (iv) зохион байгуулалтын хяналт тавих, зохицуулагч байгууллагын хяналт шалгалт хийх, баримт бичиг хөтлөх болон тайлاغнах тогтолцоог бүрдүүлэх;
 - (v) холбогдох дүрэм, журам болон тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлэх;
 - (vi) ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн шат бүрт оролцох байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой зааглан тогтоосон байх.

3. Хэлэлцэн тохиролцогч талууд цацраг идэвхт материалыг цацраг идэвхт хаягдалд тооцож зохицуулах эсэхийг шийдвэрлэхдээ энэхүү конвенцын зорилготой хэрхэн уялдаж буйг харгалзан үзнэ.

**20 дугаар зүйл
Зохицуулагч байгууллага**

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр 19 дүгээр зүйлд заасан эрх зүйн болон зохицуулалтын тогтолцооны хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий зохицуулагч байгууллагыг шинээр байгуулах буюу томилох бөгөөд хүлээсэн чиг үүргээ биелүүлэхэд нь шаардагдах хангалттай хэмжээний эрх мэдэл, чадавх, санхүүгийн болон хүний нөөцөөр хангана.

2. Хэлэлцэн тохиролцогч тал бүр үндэсний эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоондоо нийцүүлэн ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн болон тэдгээрийг зохицуулах үйл ажиллагаанд оролцож байгаа байгууллагуудын зохицуулалтын чиг үүрэг нь бусад чиг үүргээс нь хараат бус, бие даасан байх нөхцөлийг үр дүнтэй хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

**21 дүгээр зүйл
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг**

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүргийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хүлээдэг байх, түүнчлэн тэдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр хүлээсэн үүргээ биелүүлдэг байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

2. Хэрэв тийм тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд, эсхүл өөр хариуцсан этгээд байхгүй бол ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдал харьяалалд нь хамаарах Хэлэлцэн тохиролцогч тал тухайн үүргийг хүлээнэ.




**22 дугаар зүйл
Санхүүгийн болон хүний нөөц**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн ашиглалтын хугацаанд тэдгээрийн аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэргэшсэн боловсон хүчинтэй байх;

Монгол Улсын Гадаад харилцаны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

20  оньс  сарын  ёдэр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

- (ii) ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн ашиглалтын хугацаанд болон тухайн байгууламжийг ашиглалтаас гаргах үед тэдгээрийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай санхүүгийн хүрэлцэхүйц нөөцтэй байх;
- (iii) булслах байгууламжийг хаасны дараа шаардлагатай гэж үзсэн хугацааны туршид зохих ёсны зохион байгуулалтын хяналт тавих, хяналт шалгалт хийхэд шаардлагатай санхүүжилтийг олгодог байх.

**23 дугаар зүйл
Чанарын баталгаа**

Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах чанарын баталгааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

**24 дүгээр зүйл
Ашиглалтын үеийн цацрагийн хамгаалалт**

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн ашиглалтын хугацааны туршид дараах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (i) тухайн байгууламжаас тэнд ажиллагсад болон хүн амд учруулах цацрагийн шарлагыг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах, чингэхдээ эдийн засгийн болон нийгмийн хүчин зүйлсийг тооцон үзэх;
- (ii) энгийн нөхцөлд нэг ч хүн олон улсад мөрддөг цацрагийн хамгаалалтын стандартыг харгалzan тогтоосон үндэсний стандартад заасан цацрагийн тунгийн хязгаараас хэтэрсэн цацрагийн нөлөөнд өртөхгүй байх;
- (iii) цацраг идэвхт материал байгаль орчинд төлөвлөөгүй буюу хяналтгүй байдлаар алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байх.

2. Хэлэлцэн тохиролцогч тал бүр суллах ажиллагааг хязгаарлахад чиглэсэн дараах арга хэмжээг авна. Үүнд:

- (i) цацрагийн шарлагыг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах, чингэхдээ нийгэм болон эдийн засгийн хүчин зүйлсийг тооцон үзэх;

(ii) энгийн нөхцөлд нэг ч хүн олон улсад мөрддөг цацрагийн хамгаалалтын стандартыг харгалзан тогтоосон үндэсний стандартад заасан цацрагийн тунгийн хязгаараас хэтэрсэн цацрагийн нөлөөнд өртөхгүй байх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

3. Хэлэлцэн тохиролцогч тал бүр зохицуулалтад байдаг цөмийн байгууламжийн ашиглалтын хугацааны туршид цацраг идэвхт материал байгаль орчинд төлөвлөөгүй, эсхүл хяналтгүй байдлаар алдагдсан тохиолдолд алдагдлыг хянаж, түүний нөлөөг бууруулах зохих арга хэмжээг авна.

25 дугаар зүйл Ослын үеийн бэлэн байдал

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг ашиглалтад орохоос өмнө болон ашиглах хугацаанд ослын үед голомт дээр болон шаардлагатай тохиолдолд байгууламжийн гадна хэрэгжүүлэх ослын үед авах арга хэмжээний зохих төлөвлөгөөтэй байна. Тэрхүү ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг тохиромжтой хугацааны давтамжтайгаар туршиж байна.

2. Хэлэлцэн тохиролцогч тал бүр өөрийн нутаг дэвсгэрийн ойролцоо орших ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжид үүсэх цацрагийн осолд өртөх магадлалтай байвал ослын үед өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, турших чиглэлээр зохих арга хэмжээг авна.

26 дугаар зүйл Ашиглалтаас гаргах

Хэлэлцэн тохиролцогч тал бүр цөмийн байгууламжийг ашиглалтаас гаргах үеийн аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээ нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- (i) мэргэшсэн боловсон хүчин болон хүрэлцэхүйц санхүүгийн нөөцтэй байх;
- (ii) ашиглалтын үеийн цацрагийн хамгаалалт, /цацраг идэвхт материалыг/ суллах болон төлөвлөөгүй, эсхүл хяналтгүй байдлаар алдагдахтай холбоотой 24 дүгээр зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэх;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

20²² оны 20 сарын 20 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

- (iii) ослын үеийн бэлэн байдлын тухай 25 дугаар зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэх;
- (iv) ашиглалтаас гаргах ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллийг бүртгэж, хадгалах.

5 ДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл Хил дамжуулан хүргэх

1. Хил дамжуулан хүргэх ажиллагаанд оролцож буй Хэлэлцэн тохиролцогч тал бүр тухайн ажиллагааг энэхүү конвенц болон холбогдох заавал дагаж мөрдөх шинжтэй олон улсын баримт бичигт нийцүүлэн явуулах нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

Ийнхүү хангахдаа:

- (i) гарал үүслийн улс болох Хэлэлцэн тохиролцогч тал нь гагцхүү хүлээн авагч улсад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр хил дамжуулан тээвэрлэх зөвшөөрөл олгож, тийнхүү хүргэх ажиллагааг хийхэд чиглэсэн зохих арга хэмжээг авна;
- (ii) дамжин өнгөрөх улсаар хил дамжуулан хүргэх ажиллагааг уг ажиллагаанд ашиглаж буй тээвэрлэлтийн төрөлд хамааралтай олон улсын үүргийн дагуу гүйцэтгэнэ;
- (iii) хүлээн авагч улс болох Хэлэлцэн тохиролцогч тал нь хил дамжуулан хүргэх зөвшөөрлийг гагцхүү ашигласан түлш эсхүл цацраг идэвхт хаягдлыг энэхүү конвенцод нийцүүлэн зохицуулах захиргааны болон техникийн чадавх болоод зохицуулалтын бүтэцтэй бол олгоно;
- (iv) гарал үүслийн улс болох Хэлэлцэн тохиролцогч тал нь хил дамжуулан хүргэх ажиллагаа эхлэхээс өмнө хүлээн авагч улс энэ зүйлийн (iii) дахь хэсэгт заасан шаардлагуудыг хангасан гэж үзсэн тохиолдолд хил дамжуулан хүргэх ажиллагааг зөвшөөрнө;
- (v) гарал үүслийн улс болох Хэлэлцэн тохиролцогч тал нь хил дамжуулан хүргэх ажиллагаа энэ зүйлд заасан шаардлагын дагуу явагдаагүй, эсхүл тийнхүү явагдах боломжгүй болсон бөгөөд өөр аюулгүй зохицуулалт хийх боломжгүй байвал тухайн тээврийг

арилцалны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2022 оны 06 сарын 20-өдөр
Улаанбаатар хот

өөрийн нутаг дэвсгэр рүү буцаан орохыг зөвшөөрөхөд чиглэсэн зохих арга хэмжээг авна.

2. Хэлэлцэн тохиролцогч тал нь өөрийн ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдлыг Өмнөд өргөргийн 60 градусаас урагш газарт хадгалах, эсхүл булшлахаар тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

3. Энэхүү конвенцын аль ч заалт дараах эрхийг дордуулах, эсхүл хөндөхгүй.
Үүнд:

- (i) олон улсын эрх зүйн дагуу бүх улс усан онгоц болон агаарын хөлгөөр далайн, голын болон агаарын тээвэр хийх эрх, эрх чөлөөгөө эдлэх эрх;
- (ii) цацраг идэвхт хаягдлыг боловсруулах зорилгоор экспортоор авсан Хэлэлцэн тохирогч талын эдлэх, цацраг идэвхт хаягдал болон боловсруулах ажиллагааны дараа үүсэх бусад бүтээгдэхүүнийг гарал үүслийн улсад нь буцаах, эсхүл буцаахаар олгох эрх;
- (iii) өөрийн ашигласан түлшийг дахин боловсруулах зорилгоор экспортлох Хэлэлцэн тохиролцогч талын эрх;
- (iv) ашигласан түлшийг дахин боловсруулах зорилгоор экспортоор авсан Хэлэлцэн тохиролцогч талын эдлэх, цацраг идэвхт хаягдал болон дахин боловсруулах ажиллагааны дүнд үүссэн бусад бүтээгдэхүүнийг гарал үүслийн улсад нь буцаах, эсхүл буцаахаар олгох эрх.

28 дугаар зүйл Ашиглагдахгүй болсон битүү үүсгүүр

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр үндэсний хууль тогтоомжийнхoo хүрээнд ашиглагдахгүй болсон битүү үүсгүүрийг эзэмших, дахин үйлдвэрлэх, эсхүл булшлах ажиллагааг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авна.

2. Хэлэлцэн тохиролцогч тал нь үндэсний хууль тогтоомжийнхoo хүрээнд хэрэв ашиглагдахгүй болсон битүү үүсгүүрийг түүнийг буцаан авах, эзэмших чадавхтай нь нотлогдсон үйлдвэрлэгчид нь буцаах асуудлыг хуульчлан зөвшөөрсөн бол тухайн үүсгүүрийг өөрийн нутаг дэвсгэрт буцаан оруулахыг зөвшөөрөх ёстай.

6 ДУГААР БҮЛЭГ
ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХУРАЛ

29 дүгээр зүйл
Бэлтгэл хурал

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын бэлтгэл хурлыг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор зохион байгуулна.

2. Энэ хурлаар Хэлэлцэн тохиролцогч талууд:

- (i) 30 дугаар зүйлд заасан тайлан хэлэлцэх анхны хурлын товыг тогтооно. Тайлан хэлэлцэх анхны хурлыг аль болох богино хугацааны дотор, гэхдээ энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гучин сараас хэтрэхгүй хугацааны дотор зохион байгуулна.
- (ii) Үйл ажиллагааны дүрэм болон Санхүүгийн дүрмийг боловсруулж, санал нэгтэйгээр батална.
- (iii) Үйл ажиллагааны дүрэмд нийцүүлэн дараах зүйлсийг тусгайлан тогтооно. Үүнд:
 - a) 32 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлэх үндэсний тайлангийн хэлбэр, бүтцийн талаарх удирдамж;
 - b) тэрхүү тайланг хүргүүлэх өдөр;
 - c) тэрхүү тайланг хэлэлцэх үйл ажиллагааны дэг.

3. Энэхүү конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон, эсхүл батламжилсан боловч түүний хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болоогүй байгаа аливаа улс, эсхүл бус нутгийн нэгдлийн буюу бусад төрлийн байгууллага бэлтгэл хуралд энэ конвенцын Оролцогч талын нэгэн адил /эрх, үүрэгтэйгээр/ оролцож болно.

30 дугаар зүйл
Тайлан хэлэлцэх хурал

1. Хэлэлцэн тохиролцогч талууд 32 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн тайланг хэлэлцэх зорилгоор хурал зохион байгуулна.

2. Тайлан хэлэлцэх хурал бүрийн үеэр Хэлэлцэн тохиролцогч талууд:

- (i) тайлан хэлэлцэх дараагийн хурлын товыг тогтоох бөгөөд хурал хоорондын хугацаа нь гурван жилээс хэтэрч болохгүй;

22

*Гарын үсэг /Signature/
2012 онь 26 сарын 21 өдөр
Улзанбаатар хот*

- (ii) 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон зохицуулалтыг дахин хянаж болох бөгөөд үйл ажиллагааны дүрэмд өөрөөр заагаагүй бол тухайн зохицуулалтад оруулсан өөрчлөлтийг санал нэгтэйгээр батална. Түүнчлэн санал нэгтэйгээр Үйл ажиллагааны дүрэм болон Санхүүгийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3. Тайлан хэлэлцэх хурал бүрийн үеэр Хэлэлцэн тохиролцогч тал нэг бүр Хэлэлцэн тохиролцогч бусад талаас ирүүлсэн тайланг хэлэлцэх, тайлангийн талаар тодруулга авах бодит боломжоор хангагдана.

31 дүгээр зүйл Ээлжит бус хурал

Хэлэлцэн тохиролцогч талуудын ээлжит бус хурлыг:

- (i) хуралд оролцож, санал өгсөн Хэлэлцэн тохиролцогч талуудын олонхийн саналаар ээлжит бус хурал хийхээр тохиролцсон бол; эсхүл
- (ii) Хэлэлцэн тохиролцогч аль нэг талаас ээлжит бус хурал хийх хүсэлт гаргаж, уг хүсэлтийг 37 дугаар зүйлд заасан Нарийн бичгийн дарга нарын газар Хэлэлцэн тохиролцогч талуудад мэдэгдсэн бөгөөд Хэлэлцэн тохиролцогч талуудын олонх нь хүсэлтийг дэмжиж буйгаа мэдэгдсэн тохиолдолд хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дотор хуралдуулна.

32 дугаар зүйл Тайлан хүргүүлэх

1. 30 дугаар зүйлд заасны дагуу Хэлэлцэн тохиролцогч тал тус бүр тайлан хэлэлцэх Хэлэлцэн тохиролцогч талуудын хурал бүрт үндэсний тайлангаа хүргүүлнэ. Энэ тайландаа энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тусгана. Хэлэлцэн тохиролцогч тал бүрийн хувьд тайлан нь мөн дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:

- (i) ашигласан түлшний менежментийн бодлого;
- (ii) ашигласан түлшний менежментийн практик үйл ажиллагаа;
- (iii) цацраг идэвхт хаягдлын менежментийн бодлого;
- (iv) цацраг идэвхт хаягдлын менежментийн практик үйл ажиллагаа;
- (v) цацраг идэвхт хаягдлыг тодорхойлох болон ангилахад ашигладаг шалгуур үзүүлэлт.

Монгол Улсын Гадаад Харилцааны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

2022 оны 2 сарын 2 одөр
Улаанбаатар хот

2. Түүнчлэн тайландаа зүйлсийг тусгана. Үүнд:

- (i) энэхүү конвенцын үйлчлэлд хамаарах ашигласан түлшний менежментийн байгууламжийн жагсаалт, тэдгээрийн байршил, үндсэн зориулалт болон онцлог шинж чанар;
- (ii) энэхүү конвенцын үйлчлэлд хамаарах хадгалсан болон булшилсан ашигласан түлшний данс бүртгэл. Уг данс бүртгэлд тухайн материалын тодорхойлолтыг тусгах ба боломжтой бол түүний жин болон цацраг идэвхийн нийт түвшний талаарх мэдээллийг оруулах;
- (iii) энэхүү конвенцын үйлчлэлд хамаарах цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн жагсаалт, тэдгээрийн байршил, үндсэн зориулалт болон онцлог шинж чанар;
- (iv) энэхүү конвенцын үйлчлэлд хамаарах, дараах төрлийн цацраг идэвхт хаягдлын данс бүртгэл. Үүнд:
 - a) цацраг идэвхт хаягдлын менежментийн болон цөмийн түлшний циклийн байгууламжуудад хадгалагдаж буй;
 - b) булшилсан; эсхүл
 - c) урьд өмнөх практик үйл ажиллагааны үр дүнд бий болсон.

Энэхүү данс бүртгэлд материалын тодорхойлолтоос гадна түүний хэмжээ эзлэхүүн, жин, цацраг идэвхт, эсхүл онцгой цацраг идэвхт цөм зэргийн талаарх бусад зохих, боломжит мэдээллийг тусгасан байна.

- (v) ашиглалтаас гаргах шатанд байгаа цөмийн байгууламжийн жагсаалт болон тухайн байгууламж дахь ашиглалтаас гаргах үйл ажиллагааны явц.

**33 дугаар зүйл
Хуралд оролцох**

1. Хэлэлцэн тохиролцогч тал бүр Хэлэлцэн тохиролцогч талуудын хуралд оролцох бөгөөд тухайн талыг төлөөлөн нэг төлөөлөгч хуралд оролцоно. Шаардлагатай тохиолдолд түүнтэй адилтгах бусад төлөөлөгчид, мэргэжилтнүүд болон зөвлөхүүд оролцож болно.

2. Хэлэлцэн тохиролцогч талууд санал нэгтэйгээр шийдвэрлэсэн тохиолдолд энэхүү конвенцоор зохицуулсан асуудал эрх хэмжээнд нь хамаарах засгийн газар хоорондын аливаа байгууллагыг аливаа хурал, эсхүл тусгай хуралд ажиглагчаар оролцохыг урьж болно. Ажиглагч нь 36 дугаар зүйлийн заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа бичгээр урьдчилан мэдэгдэх шаардлагатай.

Монгол Улсын Садаад хариуцаачны яам
АЛЬАН ЕСЛЫ ОРЧУУЛГА МОНГОЛЫН

Гарын үсэг /Signature/ 

2022 оны 04 сарын 24-өдөр
Улаанбаатар хот

**34 дүгээр зүйл
Тайлангийн дүгнэлт**

Хэлэлцэн тохиролцогч талууд хурлаар хэлэлцсэн асуудал болон хүрсэн дүгнэлтийг тусгасан баримт бичгийг санал нэгтэйгээр батлах ба тухайн баримт бичгийг олон нийтэд нээлттэй байлгана.

**35 дугаар зүйл
Хэл**

1. Үйл ажиллагааны дүрэмд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлын хэл нь араб, хятад, англи, франц, орос болон испани хэл байна.
2. 32 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн тайланг түүнийг хүргүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талын албан ёсны хэлээр, эсхүл Үйл ажиллагааны дүрмээр тохирох тодорхой нэг хэлээр боловсруулна. Тайланг /Үйл ажиллагааны дүрэмд/ тохиролцсон тодорхой хэлээр бус, Хэлэлцэн тохиролцогч талын албан ёсны хэлээр боловсруулсан бол тухайн Хэлэлцэн тохиролцогч тал нь тайлангийн тохиролцсон хэл дээрх орчуулгыг хүргүүлнэ.
3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас үл хамааран, Нарийн бичгийн дарга нарын газар нь хурлын бусад хэлээр боловсруулж ирүүлсэн тайланг тохиролцсон хэлнээ орчуулах ажлыг төлбөртэйгөөр гүйцэтгэж болно.

**36 дугаар зүйл
Нууцлал**

1. Энэхүү конвенцын заалтууд нь Хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу эдлэх буюу хүлээх, мэдээллийг задруулахаас хамгаалах эрх, үүргийг хөндөхгүй. Энэ зүйлийг тодорхой болгох зорилгоор “мэдээлэл” гэдэгт үндэсний аюулгүй байдал, эсхүл цөмийн материалын биет хамгаалалттай холбоотой мэдээлэл, оюуны өмчийн эрхээр, эсхүл үйлдвэрлэлийн болон худалдааны нууцлалын хүрээнд хамгаалагдсан мэдээлэл болон хувийн мэдээлэл хамаарна.
2. Энэхүү конвенцын хүрээнд Хэлэлцэн тохиролцогч аль нэг талаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсны дагуу хамгаалагдсан мэдээлэл гэж тодорхойлон аливаа мэдээллийг гаргаж өгсөн тохиолдолд уг мэдээллийг зөвхөн тухайн гаргаж өгсөн зорилгоор ашиглах бөгөөд түүний нууцлалд хүндэтгэлтэй хандана.
3. З дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү конвенцын үйлчлэх хүрээнд хамаарах ашигласан түлш, эсхүл цацраг идэвхт хаягдалтай холбоотой мэдээллийн хувьд энэхүү конвенцын заалтууд нь дараах асуудлыг

шийдвэрлэхтэй холбогдуулж зөвхөн Хэлэлцэн тохиролцогч талын эдлэх эрхийг хөндөхгүй. Үүнд:

- (i) тухайн мэдээлэл нь нууц эсхүл түүнийг нээлттэй болгохыг хориглож хяналтад авсан эсэх;
- (ii) дээрх (i) заалтад дурдсан мэдээллийг энэхүү конвенцын хүрээнд гаргаж өгч болох эсэх;
- (iii) хэрэв энэхүү конвенцын хүрээнд дээрх мэдээллийг гаргаж өгөх бол тэдгээр мэдээллийн нууцлалын нөхцөл, болзол.

4. 30 дугаар зүйлд заасны дагуу хуралдсан үндэсний тайлан хэлэлцэх хурал бурийн үеэр өрнөсөн хэлэлцүүлгийн агуулга нууц байна.

37 дугаар зүйл Нарийн бичгийн дарга нарын газар

1. Олон улсын атомын энергийн агентлаг (цаашид “Агентлаг” гэх) нь Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлын хувьд Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг гүйцэтгэнэ.

2. Нарийн бичгийн дарга нарын газар нь:

- (i) 29, 30 болон 31 дүгээр зүйлд дурдсан Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлыг хуралдуулах, бэлтгэл ажлыг хангах болон хурлын үеэрх үйлчилгээг хариуцах,
- (ii) энэхүү конвенцын заалтын дагуу хүлээн авсан, эсхүл боловсруулж бэлтгэсэн мэдээллийг Хэлэлцэн тохиролцогч талуудад хүргэх үүргийг гүйцэтгэнэ.

Дээрх (i) болон (ii) заалтад заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан Агентлагаас гаргасан зардлыг Агентлаг өөрийн төсвийн хүрээнд хариуцна.

3. Хэлэлцэн тохиролцогч талууд санал нэгтэйгээр Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлыг дэмжин бусад үйлчилгээ үзүүлэхийг Агентлагаас хүсэж болно. Агентлаг нь тухайн үйлчилгээг хэрэв боломжтой бол өөрийн хөтөлбөр болон батлагдсан төсвийн хүрээнд үзүүлж болно. Хэрэв тийм боломжгүй бол Агентлаг тухайн үйлчилгээг бусад эх үүсвэрээс авах сайн дурын санхүүжилтийн үндсэн дээр үзүүлж болно.



7 ДУГААР БҮЛЭГ
ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

38 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

Энэхүү конвенцыг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хоёр буюу түүнээс дээш Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талууд тухайн маргааныг шийдвэрлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлын хүрээнд зөвлөлдөнө. Зөвлөгөөн үр дүнгүй болсон тохиолдолд Олон улсын атомын энергийн агентлагийн журам, практик зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу маргааныг шийдвэрлүүлэхээр зуучлагч, эвлэрүүлэх комисс болон арбитрт хандаж болно.

39 дүгээр зүйл
Гарын үсэг зурах, соёрхон батлах,
хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох

1. Энэхүү конвенцод Вена хотод байрлах Агентлагийн төв байранд 1997 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн түүнийг хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд бүх гарын үсэг зурахад нээлттэй байна.
2. Энэхүү конвенцод гарын үсэг зурсан улс түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах үүрэгтэй.
3. Энэхүү конвенцод түүнийг хүчин төгөлдөр болсноос хойш бүх улс нэгдэн ороход нээлттэй байна.
4.
 - (i) Гишүүнчлэл нь тусгаар улсуудаас бүрдэх, энэхүү конвенцоор зохицуулсан асуудлаар олон улсын хэлэлцээр байгуулах хэлэлцээ хийх, байгуулах, хэрэгжүүлэх эрх хэмжээ бүхий бүс нутгийн нэгдлийн буюу бусад төрлийн байгууллага энэхүү конвенцод гарын үсэг зурж батламжлах, эсхүл нэгдэн ороход нээлттэй байна.
 - (ii) Тэдгээр байгууллага нь эрх хэмжээнийхээ хүрээнд энэхүү конвенцын дагуу Оролцогч улсуудын хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг өөрийн нэрийн өмнөөс эдэлж, хэрэгжүүлнэ.
 - (iii) Энэхүү конвенцод нэгдэн орох үедээ тэрхүү байгууллага нь аль улс тухайн байгууллагын гишүүн болох, тус байгууллагын хувьд энэхүү конвенцын аль заалт үйлчлэх болон тэдгээр заалтаар зохицуулсан арилцааны яам

салбар дахь тухайн байгууллагын эрх хэмжээний талаар тусгасан мэдэгдлийг 43 дугаар зүйлд заасан Эх хадгалагчид хүргүүлнэ.

- (iv) Тэрхүү байгууллага нь өөрийн гишүүн улсуудын саналын эрхээс гадна нэмэлт санал өгөх эрхгүй байна.

5. Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон эсхүл батламжилсан тухай батламж жуух бичгийг Эх хадгалагчид хадгалуулна.

40 дүгээр зүйл Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай хорин тав дахь батламж жуух бичгийг Эх хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно. Чингэхдээ эдгээр хорин таван батламж жуух бичгийн арван тав нь ашиглалтад буй цөмийн эрчим хүчний станц бүхий улсуудаас ирсэн байх ёстой.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлийг хангахад шаардлагатай сүүлчийн батламж жуух бичгийг хүлээн авсан өдрөөс хойш энэхүү конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон, эсхүл батламжилсан улс, эсхүл бус нутгийн нэгдлийн буюу бусад төрлийн байгууллагын хувьд энэхүү конвенц нь тухайн улс, эсхүл байгууллага зохих батламж жуух бичгээ Эх хадгалагчид хадгалуулсан өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно.

41 дүгээр зүйл Конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Хэлэлцэн тохиролцогч аливаа тал энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг тайлан хэлэлцэх хурал, эсхүл ээлжит бус хурлаар хэлэлцэнэ.

2. Санал болгосон аливаа нэмэлт, өөрчлөлтийн бичвэр болон нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг Эх хадгалагчид хүргүүлнэ. Эх хадгалагч нь тухайн нэмэлт, өөрчлөлтийн төслийг уг асуудлыг хэлэлцэх хурал болохоос дор хаяж ер хоногийн өмнө Хэлэлцэн тохиролцогч талуудад тараана. Тухайн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн аливаа саналыг Эх хадгалагч Хэлэлцэн тохиролцогч талуудад тараана.

3. Хэлэлцэн тохиролцогч талууд нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцсэний үндсэн дээр тухайн нэмэлт, өөрчлөлтийг батлах эсэх асуудлыг санал нэгтэйгээр шийдвэрлэх бөгөөд тийнхүү санал нэгтэйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд уг асуудлыг Дипломат зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх эсэх шийдвэрийг гаргана. Нэмэлт, өөрчлөлтийн төслийг Дипломат зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх шийдвэрийг

Монгол Улсын Задарж Улсынцааны яам
АЛЬАН ЕСНЫ ОРЧУУХ ГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

20 дундажны 20 сарын 20 өдөр
Улаанбаатар хот

хуралд оролцож, саналаа өгсөн Хэлэлцэн тохиролцогч талуудын гуравны хоёрын саналаар гаргах бөгөөд чингэхдээ тухайн хурлаар санал хураах үед Хэлэлцэн тохиролцогч бүх талын талаас доошгүй хувь нь оролцсон байх ёстай.

4. Энэхүү конвенцод оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, батлах Дипломатын зөвлөгөөнийг Эх хадгалагч зарлан хуралдуулах бөгөөд чингэхдээ энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу зохих шийдвэр гарснаас хойш нэг жилийн дотор хуралдуулна. Дипломат зөвлөгөөн нь тухайн нэмэлт, өөрчлөлтийг аль болох санал нэгтэйгээр батлах нөхцөлийг хангахад чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна. Хэрэв санал нэгтэйгээр баталж чадахгүй бол Хэлэлцэн тохиролцогч бүх талын гуравны хоёрын саналаар нэмэлт, өөрчлөлтийг батална.

5. Хэлэлцэн тохиролцогч талууд энэ зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт заасны дагуу баталсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл батламжлах бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл батламжилсан Хэлэлцэн тохиролцогч талын хувьд Хэлэлцэн тохиролцогч бүх талын гуравны хоёр нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл батламжилсан тухай батламж жуух бичгээ Эх хадгалагчид хүргүүлсэн өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа уг нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл батламжилсан Хэлэлцэн тохиролцогч талын хувьд нэмэлт, өөрчлөлт нь тухайн тал энэ тухай батламж жуух бичгээ Эх хадгалагчид хүргүүлсэн өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно.

42 дугаар зүйл Цуцлах

- Хэлэлцэн тохиролцогч аливаа тал Эх хадгалагчид бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцыг цуцалж болно.
- Ийнхүү цуцлах нь энэ тухай мэдэгдлийг Эх хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа, эсхүл мэдэгдэлд заасан түүнээс хойших өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

43 дугаар зүйл Эх хадгалагч

- Агентлагийн Ерөнхий захирал нь энэхүү конвенцын Эх хадгалагч байна.
- Эх хадгалагч нь Хэлэлцэн тохиролцогч талуудыг дараах мэдээллээр хангана.
Үүнд:

- (i) 39 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү конвенцод гарын үсэг зурсан тухай болон түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, **ХУЛЭЭНБАА ЗӨВШӨӨРСӨН, УУПГА МОН**

баталсан, нэгдэн орсон, эсхүл батламжилсан тухай батламж жуух бичгийг хүлээн авсан тухай;

- (ii) 40 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр болох өдөр;
- (iii) 42 дугаар зүйлд заасны дагуу гаргасан энэхүү конвенцоос гарах тухай мэдэгдэл болон түүний огноо;
- (iv) 41 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Хэлэлцэн тохиролцогч талуудаас ирүүлсэн санал, холбогдох Дипломат зөвлөгөөнөөр эсхүл Хэлэлцэн тохиролцогч талуудын хурлаар баталсан нэмэлт, өөрчлөлт болон тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдөр.

44 дүгээр зүйл Эх бичвэр

Энэхүү конвенцын араб, хятад, англи, франц, орос болон испани хэлээрх эх бичвэрүүд адил хүчинтэй байх бөгөөд эх бичвэрүүдийг Эх хадгалагчид хадгалуулна. Эх хадгалагч нь эх бичвэрүүдийн баталгаат хуулбарыг Хэлэлцэн тохиролцогч талуудад хүргүүлнэ.

Дээр дурдсаныг нотлон, гарын үсэг зурах эрх зохих ёсоор олгогдсон дор дурдсан төлөөлөгчид энэхүү конвенцод гарын үсэг зурав.

Вена хотноо 1997 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр үйлдэв.

